



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

□ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал  
хуралдуулах тухай □

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ыг тус тус үндэслэн "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2022 оны 3 сарын 18-ны хурлын саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 10:00 цагт Монгол Улсын Сангийн яам, С.Данзангийн гудамж, Засгийн газар II байр Д корпус т зохион байгуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.

- а) Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт;
- б) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө;
- в) Компанийн 2022 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин.

3. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэ тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталж нийтэд мэдээлэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 өдрийн дотор Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.

4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг энэ тогтоолын Хавсралт №2-т зааснаар баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.СҮХ-ОЧИР

1522610007

“МХБ” ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2022 оны 3 дугаар сарын 18-ний өдрийн  
05 дугаар Тогтоолын 1 дүгээр хавсралт



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК
Хаяг:	Сүхбаатарын талбай-3, Улаанбаатар 15160, Монгол улс
Хурал хуралдах өдөр, цаг:	2022 оны 4 сарын 29
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Монгол Улсын Сангийн яам, С.Данзангийн гудамж, Засгийн газар II байр Д корпус, Улаанбаатар хот
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	ТУЗ-ийн 2022 оны 3 сарын 18-ны өдрийн Тогтоол № 05
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	1. Хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол.
Баримт бичгийн хуудасны тоо:	..... ширхэг
	..... хуудас

2022 оны 03 дүгээр сарын 18-ны өдөр

“МХБ” ТӨХК-ийн Төлөөлөн Улирдах Зөвлөлийн  
2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн  
05 дугаар Тогтоолын 2 дугаар хавсралт



КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ  
АСУУДАЛТАЙ ХОЛБОГДСОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ  
БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ

1. Компанийн санхүүгийн жилийн тайлан;
2. Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
3. Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан журмын дагуу хийсэн эсэх тухай аудитын байгууллагын дүгнэлт;
4. Бизнесийн үйл ажиллагааны тайлан;
5. Хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчээс шаардсан бусад мэдээлэл.